



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 55

Улаанбаатар хот

Үл хөдлөх хөрөнгө акталж,
данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх, журам"-ын 6.2.2, 6.2.5, 6.4.5, 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн Прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2011 оны 48/14/254 дүгээр дүгнэлтээр цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон нь тогтоогдсон нийт 96,850,600.00 (ерэн зургаан сая найман зуун тавин мянга зургаан зуун) төгрөгийн балансын үнэ, 96,816,626.00 (ерэн зургаан сая найман зуун арван зургаан мянга зургаан зуун хорин зургаан) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Ховд аймгийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын итгэмжит зөвлөх Н.Доржсүрэнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Үл хөдлөх хөрөнгийг акталж, чөлөөлсөн газрыг байгууллагын хэрэгцээнд зориулалтаар нь ашиглах, газрыг нөхөн сэргээх;


2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТЭСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

D:\Huraldaanii material\2018.03.06\togtool\04docx

0001512

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2018 оны 03 дугаар сарын 16 ны өдрийн
 55 дугаар тогтоолын хавсралт



Ховд аймгийн Прокурорын газрын балансад бүртгэлтэй акталж,
 данснаас хасах үл хөдлөх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Албан конторын барилга	1957	м.кв	243.3	92,902,400.00	92,902,400.00	-
2	Цэвэр усны шугам	1957	м	600	2,760,000.00	2,760,000.00	-
3	Бохир усны шугам	1957	м	5	365,000.00	365,000.00	-
4	Автомашинны гарааш	1999	м.кв	12	352,800.00	352,800.00	-
5	Нүүрс хадгалах байр	2004	м.кв	16	470,400.00	436,426.00	33,974.00
НИЙТ ДҮН					96,850,600.00	96,816,626.00	33,974.00
					(ерэн зургаан сая найман зуун тавин мянга зургаан зуун)	(ерэн зургаан сая найман зуун арван зургаан мянга зургаан зуун хорин зургаан)	(гучин гурван мянга есөн зуун далан дөрвөн)